

тендериин баримт бичгийн з дугаарбулэгт заасан маягтаарбусад мэдээллийн хамтаар бэлтгэж тендерт ирүүлнэ.

Тендер нь захиалагч
20. Тендер хүчинтэй байх хугацаа

- 20.1. Тендер нь захиалагч ТОӨЗ-ны 27.1-тзаасны дагуу тогтоосон тендер нээх он, сар, өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Тендерт оролцогчоос тендериин маягтад санал болгож ирүүлсэн тендер хүчинтэй байх хугацаа нь захиалагчийн тогтоосон дээрх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүний тендерииг үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж, уг тендерээс татгалзана.
- 20.2. Онцгой нөхцөл байдал үүсч тендер хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд захиалагч бүх тендерт оролцогчид хандаж өөрсдийн тендер хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлт тавина. Энэхүү хүсэлт гаргах болон түүний хариуг ирүүлэхдээ бичгээр, эсхүл утсан холбоогоор харилцана. Тендерт оролцогч тендериин баталгааг улсын орлого болгохгүйгээр уг хүсэлтээс татгалзах эрхтэй. Хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогчоос тендериинх нь агуулгыг өөрчлөхийг санал болгох, эсхүл өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхийг хориглоно. Хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогч тендериин баталгааны хүчинтэй хугацааг 21 дүгээр зүйлд нийцүүлэн мөн хугацаагаар сунгана.

Тендерт оролцогч нь мөн ТШӨХ-д заасан дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.
21. Тендерийн баталгаа

- 21.1. Тендерт оролцогч нь мөн ТШӨХ-д заасан дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.
- 21.2. Тендер шалгаруулалт олон багцтай бол нэг тендерийн баталгаа гаргаж, түүнд багц тус бүрээр тодорхойлж ирүүлнэ.
- 21.3. Захиалагч тендериин баталгааны хэмжээг багц тус бүрийн төсөвт өргтгийн 1-2 хувиар тооцож ТШӨХ-д заана.
- 21.4. Тендерийн баталгаа нь Монгол улсын, эсхүл гадаадын банкны гаргасан баталгаа байна. Тендерийн баталгааг 4 дүгээр бүлэгт заасан маягтаар, эсхүл тендер хүлээн авахаас өмнө захиалагчийн урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх эцсийн хугацаанаас хойш 28 хоногбайна.
- 21.5. Тендерийн баталгааны эх хувийг ирүүлэхдээ захиалагчийн ТШӨХ-д заасан хоног (он, сар, өдөр)-оор тооцож ирүүлнэ.
- 21.6. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- 21.7. ТОӨЗ-ны 21.1-д шаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерийг захиалагч үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.
- 21.8. Тендер нь шалгараагүй оролцогчийн тендерийн баталгааг ТОӨЗ-ны 20.1-д заасан тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн дотор захиалагч хүчингүй болгоно.
- 21.9. Шалгарсан тендерт оролцогчийн тендерийн баталгааг ТОӨЗ-ны 39 дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурж, ТОӨЗ-ны 40 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлэхэд хүчингүй болгоно.
- 21.10. Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно:
- (а) тендер нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн;
- (б) тендерт оролцогч ТОӨЗ-ны 31.2-ын дагуу тендерийн үнэд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд ТОӨЗ-ын 37.2-т заасан нөхцөл үүссэн бол;;

- (в) шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан:
- 1) ТОӨЗ-ны 39 дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зураагүй бол;
 - 2) ТОӨЗ-ны 40 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол.

22. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах 22.1. Тендерт оролцогч 14дүгээрзүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгийн эх хувиудыг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Тендерт оролцогч үүнээс гадна ТШӨХ-д заасан тоо ширхэг бүхий тендерийн хуулбар хувийг бэлтгэн хавтаслаж, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Эх хувь болон хуулбар хувиуд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтална.

22.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг хэвлэж (компьютер, бичгийн машин гэх мэт), эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Тендерт оролцогчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурна. Хэвлэмэл танилцуулга, тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг баримт бичиг үүнд хамаарахгүй.

22.3. Тендер ирүүлэхээс өмнө захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засахаас бусад тохиолдолд тендерт ямар нэг засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд зөвхөн дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар тэдгээр засвар өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.

Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

- 23. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх** 23.1. Тендерт оролцогчид өөрийн тендерийг шуудангаар, эсвэл өөрөө буюу өөрийн бие төлөөлөгчөөр захиалагчид хүргүүлнэ.
- 23.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг тус тусад нь “ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дутгуйнд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин давхар нэг дутгуйнд (гаднах) хийж битүүмжлэнэ. Тендерээ дутгуйлж, битүүмжлэхдээ ТОӨЗ-ны 23.3, 23.4-т заасныг баримтлана.
- 23.3. Доторх ба гаднах дутгуйнууд дараах шаардлагыг хангасан байх. Үүнд:
- (а) тендерт оролцогчийн нэр, хаягтай байх;
 - (б) ТШӨХ-д заасан хаягаар ТОӨЗ-ны 1.1-дзаасан захиалагчийн нэр дээр хаяглах;
 - (в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТОӨЗ-ны 1.1 болон ТШӨХ-тодорхойлсон тендер шалгаруулалтын нэр/дугаар тодорхой бичсэн байх;
 - (г) ТОӨЗ-ны 27.1-т заасан хугацаанаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж тэмдэглэгдсэн байх.
- 23.4. Хэрэв бүх дутгуйг 23.3-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нехцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө битүүмжлэл задарсан тохиолдолд захиалагч хариуцлага хүлээхгүй.

	23.5. ТОӨЗ-ны 23.1-д зааснаас өөр хэлбэрээр (электрон шуудангаар, эсвэл факсаар г.м) ирүүлсэн аливаа тендерийг захиалагч хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасныг үндэслэн хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцаана.
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	<p>24.1. Захиалагч тендерийг ТШӨХ-д заасан хаягаар, нээх огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>24.2. Захиалагч ТОӨЗ-ны 12 дугаар зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.</p>
25. Хугацаа хоцорсон тендер	25.1. Захиалагч ТОӨЗ-ны 24 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.
26. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах	<p>26.1. Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах эрхтэй.</p> <p>26.2. Тендерт нэмэлт, өөрчлөлт оруулах, солих эсхүл тендерийг буцааж авах мэдэгдлийг ТОӨЗ-ны 23 дугаар зүйлийн дагуу бэлтгэн битүүмжилж, бичиглэл хийхийн хамт доторх ба гаднах дутгуй дээр “НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ТУХАЙ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн нэмэлт бичиглэл хийж ТОӨЗ-ны 24 дүгээр зүйлд заасны дагуу захиалагчид ирүүлнэ. Тендерийг буцааж авах мэдэгдлийг утсан холбоогоор ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.</p> <p>26.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш тендерт аливаа нэмэлт өөрчлөлт хийхийг хориглоно.</p> <p>26.4. ТОӨЗ-ны 26.2-т заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүй буцаан олгоно.</p> <p>26.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаастендер хүчинтэй байх хугацааны хоорондтандерийг буцааж авах нь ТОӨЗ-ны 21 д зүйлийн дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болно.</p>

Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ

27. Тендерийг нээх	<p>27.1. Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.</p> <p>27.2. Захиалагч эхлээд “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн бичиглэл бүхий дутгуйг нээж, зарлах бөгөөд энэ хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаана. Хэрэв “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн хүсэлтэд гарын үсэг зурсан этгээд нь тендерт оролцогчийг төлөөлөх бүрэн эрх бүхий этгээд болохыг баталсан гарын үсгийн баталгаа, итгэмжлэл дагалдаж ирээгүй бол түүний үндсэн тендерийг буцаахыг зөвшөөрөхгүй бөгөөд түүнийг нээж нийтэд зарлана. Дараа нь “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ” бичиглэл бүхий тендерийг нээж зарлах бөгөөд уг тендерийг ирүүлсэн оролцогчийн урьд ирүүлсэн тендерийг нээлгүйгээр түүнд буцаан олгоно. “ТЕНДЕРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХТУХАЙ” дутгуйг түүнд харгалзах үндсэн тендерийн хамт нээж нийтэд зарлана. Хэрэв тендер солих, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг уг тендерийг ирүүлсэн оролцогчийг бүрэн төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан болохыг баталгаажуулж,</p>
--------------------	--

хүсэлтийн хамт ирүүлээгүй бол тендерийг солих, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхгүй бөгөөд урьд ирүүлсэн тендерийг дангаар нь нийтийн өмнө нээж зарлана.

27.3. Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүний үнэ, хэрэв захиалагч шаардсан бол тендерийн баталгаа байгаа эсэх, оролцогч өөрийн тендерт нэмэлт, өөрчлөлт оруулсанбол уг нэмэлт өөрчлөлтийг болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.

27.4. Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна.

- (а) тендерторолцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, эсхүл тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан буюу тендерээ солисон эсэх;
- (б) тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт(зөвшөөрсөн бол хувилбарт тендерийн үнэ), шаардлагатай бол эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;
- (в) захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх.

27.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хоцорч ирүүлснээс бусад тендерээс тендерийн нээлтийн үед татгалзахыг хориглоно.

28. Нууцлал

28.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.

28.2. Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нелөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болж болно.

28.3. Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогчид хоорондоо зөвхөн бичгээр харилцана.

29. Тендерийг тодруулах

29.1. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний ирүүлсэн тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Тодруулга авахдаа зөвхөн албан бичгээр харилцана. Гэхдээ ТОӨЗ-ны 30 дугаарзүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.

30. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох

30.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө дараах шаардлагыг хангаж буй эсэхийг нягтлана. Үүнд:

- (а) ТОӨЗ-ны 4дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасанэсэх;
- (б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж баталгаажуулсанэсэх;
- (в) шаардагдах баталгааг зөвшөөрөгдсөн маягтаар ирүүлсэнэсэх;

- (г) тендериин баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэнэс;
- (д) тендерт оролцогч ТОӨЗ-ны 4 дүгээр зүйлд заасан гэрээг хэрэгжүүлэх чадварын доод шаардлагыг хангасанэс;
- (е) ажил гүйцэтгэхэд тавигдах бусад шаардлагыг хангасан эсэх.

30.2. ТОӨЗ-ны 30.1 дэх хэсгийн (а)-(е) дэх заалтыг хангаж буй тохиолдолд тухайн тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

30.3. Шаардлагад нийцсэн тендер нь тендериин баримт бичигт тавигдсан нөхцөл шаардлага, ялангуяа тендерт оролцогчийн үйлдвэрлэлийн болон гэрээ хэрэгжүүлэх чадвар, техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээг материаллаг зөрүүгүйгээрхангасантендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг материаллаг зөрүү гэж үзнэ:

- (а) техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд серөг нөлөө үзүүлэхээр бол;
- (б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендериин баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;
- (в) тендериин баримт бичигтшаардсанаас зөрүүтэйгээр санал болгосон тендериин саналыг хүлээн зөвшөөрөх, түүнийг засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендериин өрсөлдөөнд шударга бусаар нелөөлөх бол.

30.4. Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

31. Алдааг залруулах

31.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендериин арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

- (а) too болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зурсен бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендериин маягтад заасан тендериин нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендериин нийт үнийг залруулна;
- (в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг too ширхэгээр үргүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхийлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнээс зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

31.2. Захиалагч хамгийн сайн үнэлгэдсэн тендериин үнэд залруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.

32. Нэг валютад хөрвүүлэх

32.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдол ТОӨЗ-ны 18 дугаар зүйлд зааснаас өөр валютад тендериин үнийг илэрхийлж болно. Ийм тохиолдолд захиалагч тендериин үнэлгээ, харьцуулалтыг хийхдээ тендериин үнийг тендер зарласан өдрийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

- 33. Дотоодын давуу эрх**
- 33.1. Захиалагч ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт давуу эрхийн зерүү тооцохгүй.
- 34. Тендерийг үнэлэх, харьцуулах**
- 34.1. Захиалагч зөвхөн ТОӨЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу хянан үзээд шаардлагад нийцсэн гэж тогтоосон тендерүүдийг үнэлж, харьцуулна.
- 34.2. Захиалагч тендерийг үнэлэхдээ ТОӨЗ-ны 25 дугаар зүйлийн дагуу зарлагдсан тендерийн үнэд дараах байдаар залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Үүнд:
- (а) ТОӨЗ-ны 31.1-дзаасны дагуу алдааг залруулах;
 - (б) үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь дахь магадлашгүй ажлын зардлын дүнг хасах. Харин захиалагчийн шаардсаны дагуу тендерт оролцогчийн санал болгосон ажил-өдрийн зардлыг хасахгүй;
 - (в) ТОӨЗ-ны 27.4-д заасны дагуу зарлагдсан тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тооцож, тусгах;
 - (г) Дээрх буюу энэ зүйлийн (а), (б) болон (в) заалтын дагуу хийсэн залруулга, нэмэлт өөрчлөлт, үнийн хөнгөлөлтийг тооцсон тендерийн нийт үнийг ТОӨЗ-ны 18дугаар зүйлд заасан үндсэн валют руу 32 дугаар зүйлд заасны дагуу хөрвүүлэх;
 - (д) Захиалагч материаллаг бус зөрүүтэй буюу бага хэмжээний зөрүүтэй гэж үзсэн тохиолдолд орхигдуулсан зүйлийн тоо хэмжээний дутагдал, эсвэл илүүдлийн зөрүүг мөнгөөр илэрхийлэн тооцоолж, тендерийн үнэд тусгах;
 - (е) Захиалагч зөвхөн 34.4-т тодорхойлсон үнэлгээнд харгалзах хүчин зүйлүүдийг тэдгээрт холбогдох аргачлалын дагуу тооцож тендерийн үнэд тусгах;
 - (ё) ТОӨЗ-ны 33.1-д тусгайлан заасан бол дотоодын давуу эрхийн зерүү тооцох.
- 34.3. Захиалагч нь аливаа өөрчлөлт, зерүү болон хувилбарт тендерийг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах эрхтэй. Тендерийн баримтбичгийн шаардлагыг давуулж биелүүлэх, эсхүл бусад замаар тендерийн баримтбичгийн шаардлагад заагаагүй ашиг тусыг захиалагчид санал болгосон өөрчлөлт, зерүү, хувилбарт тендер болон бусад хүчин зүйлийг захиалагч тендерийг үнэлэхэд харгалзахгүй.
- 34.4. ТШӨХ-д тусгайлан заагаагүй бол захиалагч үнэлгээнд дараах хүчин зүйлсийг харгалзахгүй:
- (а) *Гэрээний болон арилжааны зерүү:*
Гэрээний болон худалдааны нөхцөлөөс зөрүүтэйгээр санал болгосон болон орхигдуулсан зүйл бүрийн өртгийг тооцоолж үнэлгээнд харгалзана.
 - (б) *Ажлын гүйцэтгэлийн хугацаа:*
Энэ тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэх ажлыг техникийн тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэлийн хуваарийн дагууболон түүнд багтааж дуусгах шаардлагатай. Тендерторолцогчийнүүс тус хуваартүндэслэсэн байх шаардлагатай. Тус хуваарьт зааснаас өмнө дуусгавар болгохыг санал болгосон тендерт урамшуулал олгохгүй. Тус

хуваарыт зааснаас хоцорч ажлыг гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд тендерийн үнийн ТШӨХ-д заасан хувийг⁴ тендерийн үнэ дээр нэмнэ. Ажлын гүйцэтгэлийн хуваарыт зааснаас ТШӨХ-д зааснаас⁵ илүү сар хопроож дусгахыг санал болгосон тендерээс татгалзана.

(в)

Төлбөрийн хуваарийн зөрүү:

Гэрээний тусгай нөхцөлд дурдсан төлбөрийн хуваариас өөр хуваарь санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор төлбөрийн хуваарыт зааснаас өмнөтөлөгдөх дунд сарын ТШӨХ-д заасан хувь⁶-тай тэнцэххүү тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

34.5.Хэрэв тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэх ажил нь ТОӨЗ-ын 1.3-ийн дагуу хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг дараах байдлаар хийнэ. Үүнд:

(а)

багц тус бүрт ТОӨЗ-ны 34.1-34.3-т заасны дагуу тендерийн үнэлгээг хийж, харьцуулах хамгийн бага үнэтэй тендерийг тодорхойлох;

(б)

хоёр буюу түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд нөхцөлт үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерт уг нөхцөлт үнийн хөнгөлөлтийг тооцож;

(в)

дээрх үнэлгээг хийсний дараа захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсвэл бүх бацгад олгох хувилбаруудыг тооцож, тэдгээрээс хамгийн үр ашигтай хувилбарыг сонгох;

(г)

нэг тендерт оролцогчид хоёр буюу түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх олгох тохиолдолд тухайн этгээд гэрээг хэрэгжүүлэх чадварын шаардлагыг хангаж буй эсэхийг дахин магадлах. Хэрэв чадварын шаардлага хангахгүй бол тухайн этгээдэд гэрээ хэрэгжүүлэх чадварт нь тохирох багцад гэрээ байгуулах эрх олгож болно.

34.6.Шаардлагад нийцсэн тендерүүдийг ТОӨЗ-ны 34.2, 34.3 болон 34.5-дзаасны дагуу үнэлж, харьцуулах үнийг тогтоосний үндсэн дээр хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна. Хамгийн сайн үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендер үндсэн тендерээс илүү нөхцөл хангасан бол хувилбарт тендерийг шалгаруулна.

35. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах

35.1.Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.

35.2.Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлоходоо ТОӨЗ-ны 5.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТОӨЗ-ны 29 дүгээр зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТОӨЗ-ны 5.3-т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч ТОӨЗ-ны 18.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.

⁴ Ихэвчлэн 0.05 хувь.

⁵ Зөвшөөрөх хоцролтын хугацааг орлуулж бичин.

⁶ Энэ хүү нь тендер зарлах үеийн тендерийн валютын арилжааны зээлийн зонхилох хүү байна.

35.3.“Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.

36. Аливаа тендерийг сонгох, эсхүл тендерүүдээс татгалзах

36.1.Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.

E. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

37. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур

37.1.Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 34.6-д заасны дагуу хамгийн сайн гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

37.2.Хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТОӨЗ-ны 31 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй эсвэл бичгээр хариу ирүүлээгүй бол захиалагч түүний тендерээс татгалзах бөгөөд 21.8.(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгож, хуулийн 29.3 дахь хэсэгт заасныг үндэслэн удаах хамгийн сайн үнэлэгдсэн тендер шрүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

38. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

38.1.Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдлийг тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө шалгарсан тендерт оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

38.2.Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг мэдэгдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор гэрээг баталгаажуулж гарын үсэг зурахыг хориглоно. Энэ заалтыг зөрчиж байгуулсан гэрээ нь хуулийн 42.1.2-т зааснаар хүчин төгөлдөр бус гэрээ гэж тооцох үндэслэл болно.

38.3.Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь гэрээ байгуулах үндэслэл болно. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл гаргаснаар тендерт оролцогч 40 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлж, 39дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурах хүртэл захиалагч гэрээ байгуулах эрх авсан тендерт оролцогч нарын хооронд хэлцэл хийгдсэн гэж үзнэ.

38.4.Захиалагч нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас www.e-procurement.mnвэбсайтад тендерийн нэр болон багцийн дугаарыг дараах мэдээллийн хамтаар нийтэлнэ:

- 1) Тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
- 2) Тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;
- 3) Нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;
- 4) Тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Тухайн тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэх ажлын талаарх дор дурдсан өгөгдөл нь ТОӨЗ-ны холбогдох зүйл, заалтад нэмэлт мэдээлэл оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл заалттай зөрчилдвэл энэхүү ТШӨХ-д дурдсан мэдээллийг зөв гэж үзнэ.

ТОӨЗ-ны холбогдох заалт	A. Ерөнхий зүйл
ТОӨЗ 1.1	<p>Захиалагч нь: <i>Үндэсний аудитын газар</i> <i>Хаяг: УБ хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын ГУ байр,</i> <i>Утас: 261585, 329871</i></p>
ТОӨЗ 1.1	<p>Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: <i>Тендер шалгаруулалтын нэр: Оффисын өрөөний засварын ажил</i> <i>Тендер шалгаруулалтын дугаар: УАГ-2015/01</i></p>
ТОӨЗ 1.2	Ажил гүйцэтгэж дусах хугацаа нь: <i>2015 оны 09 сарын 01-ний өдөр</i>
ТОӨЗ 1.3	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Энэхүү тендер шалгаруулалт нь нэг багцтай.</i> <i>Оффисын өрөөний засварын ажил: Багц 1</i></p>
ТОӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Урсгал зардал</i>
ТОӨЗ 4.4.(в)	Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: <i>“тийм”</i> <i>Барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл</i>
ТОӨЗ 5.2	Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх:
ТОӨЗ 5.2.(б)	<p>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <i>Сүүлийн 2 жил</i> Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай эсэх: <i>“шаардлагатай”</i></p>
ТОӨЗ 5.2 (г)	Хийж гүйцэтгэсэн барилгын ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлэх шаардлагатай жилийн тоо: <i>Сүүлийн 2 жил</i>

ТОӨЗ 5.2 (д)	<p>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <i>Сүүлийн 2 жисл</i></p> <p><i>2013-2014 онуудад хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалтыг доорх загварын дагуу ирүүлнэ. Сүүлийн 2 жислд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээний үргийн билэлтийг захиалагчийн техник, хяналт хийсэн хуулийн этгээдээс өгсөн тодорхойлолтыг үндэслэн гэрээг хэрэгжүүлэх чадварын үзлэгээнд харгалзан узнэ. Гүйцэтгэсэн ажлын гэрээ болон ажил хүлээлгэж өгсөн актын хуулбарыг хавсаргана. Дуусаагүй гэрээний хувьд тайлбар хийсэн байна.</i></p> <table border="1" data-bbox="443 511 1455 780"> <thead> <tr> <th>№</th><th>Гэрээний нэр</th><th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс</th><th>Төсөвт өртөг</th><th>Дууссан, эсхүл дусах хугацаа</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr> <td></td><td>ДҮН</td><td></td><td></td><td></td></tr> </tbody> </table>	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс	Төсөвт өртөг	Дууссан, эсхүл дусах хугацаа	1						ДҮН			
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс	Төсөвт өртөг	Дууссан, эсхүл дусах хугацаа												
1																
	ДҮН															
ТОӨЗ 5.2 (з)	<i>Сүүлийн 2 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үргээ ноцтой зөрчсон эсэх талаар шүүхийн тодорхойлолт ирүүлнэ.</i>															
ТОӨЗ 5.3 (а)	<p>Борлуулалтын хэмжээ: <i>Сүүлийн 2 жисл</i></p> <p><i>Сүүлийн 2 жилийн аль нэг жислд борлуулалтын орлого нь 300.000.000 /гурван зуун сая/ төгрөг ба түүнээс дээш байх.</i></p>															
ТОӨЗ 5.3 (б)	<p>Ижил төстэй ажлыг ядаж нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа:</p> <p><i>Сүүлийн 2 жисл, ижил төстэй ажлын гэрээ, ажил хүлээлгэн өгсөн комиссын актыг хавсаргана.</i></p>															
ТОӨЗ 5.3 (в)	<p>Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд:</p> <p><i>Засварын ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж</i></p>															
ТОӨЗ 5.3 (г)	<p>Ерөнхий инженер нь гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх хугацаа: <i>2 жисл</i></p> <p>Түүний дотроос гэрээг хариуцаж ажилласан туршлагатай байх хугацаа: <i>2 жисл</i></p>															
ТОӨЗ 5.3 (д)	<p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн⁷ нийт дүн: <i>Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошигүй байна.</i></p>															
ТОӨЗ 5.3 (е)	<p><i>Тендерт оролцогч нь: Сүүлийн 2 жисл буюу 2013, 2014 оны аль нэг жислд ашигтай ажилласан байна.</i></p>															

⁷ Авх боломжтой зээл гэдэгт зээлжих баталгаажсан эрх, харилцагч банкнаас зээл олгох албан мэдэгдэл зэрэг байж болно.